

## ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ЗУРАГЛАЛ

Э.Гэрэлт-Од /улс төр судлаач, доктор  
Orcid id: [0009-0008-1748-9566](https://orcid.org/0009-0008-1748-9566)

М.Энхбадрал, /социологийн магистр  
Orcid id: [0000-0002-7037-9162](https://orcid.org/0000-0002-7037-9162)

Ж.Батболд /социологич  
Orcid id: 00009-00006-6392-3242

Г.Доржтүвдэн /социологич  
Orcid id: 0000-0002-8993-754X

Г.Гэсэр /улс төр судлаач  
Миланы их сургуулийн докторант  
Orcid id: 0009-0003-3646-2055

**Abstract:** *The study "Mapping Citizens' Political Ideologies, Political Participation, and Awareness" was conducted by the research team of the National Center for Comprehensive Development, commissioned by the Parliamentary Research and Development Institute. This article presents a summary of the study's key findings. Understanding the ideological orientations of political parties is essential for analyzing their core policies, values, goals, and approaches to societal issues. Extending this lens to citizens, the study explored political ideologies among the public through seven key dimensions—state organization, economy, social policy, human rights, family, and environment—along with 12 corresponding sub-dimensions. Using a set of evaluative questions, the research identified individuals' political positions within these categories, offering insights into the broader ideological landscape and civic engagement trends.*

**Key words:** *Political ideology, political party, political ideology of citizens, liberal ideology, conservative ideology, social democratic ideology.*

### Удиртгал

Иргэдийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлох судалгаа нь үндэсний хэмжээнд улс төрийн орчин, улс төрийн намын нөхцөл байдал, хөгжлийн хандлагыг судлах чухал арга хэрэгсэл юм. Уг судалгаа нь иргэдийн улс төрийн оролцоо, санал бодол, хандлага, үнэт зүйлсийн өөрчлөлтийг хэмжих суурь болох боломжтой.

Иргэдийн улс төрийн үзэл баримтлал, хандлага, сонголт нь улс төрийн оролцоог нөхцөлдүүлэх хүчин зүйл болохын хувьд сонгууль, хуулийн хэрэгжилт, төрийн бодлогод мөн үлэмж нөлөөлдөг. Иргэдийн улс төрийн үзэл баримтлал нь нийгэм, эдийн засгийн болон соёлын өөрчлөлттэй холбоотой байдаг. Тиймээс уг судалгаагаар эдгээр өөрчлөлтийн үед, иргэдийн ойлголт, хандлага хэрхэн хөгжиж байгааг тодорхойлж болох юм. Улс төрийн үзэл баримтлал, түүний өөрчлөлт нь нийгмийн тогтвортой байдалд нөлөөлөх тул уг судалгааг ашиглан, засгийн газрын бодлого, стратегийг сайжруулах боломжтой.

Иргэдийн улс төрийн үзэл баримтлалыг судалснаар сонгогчийн боловсролыг сайжруулах арга замыг тодруулах боломжтой бөгөөд иргэдийн мэдээлэлтэй, утга учиртай оролцоог дэмжих, улс төрийн идэвхийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Цаашлаад уг судалгаа нь зөвхөн иргэдийн үзэл бодлыг тодруулах бус улс төрийн институтүүдийн чадавхыг хэмжих, тэр дундаа улс төрийн намын хөгжилд чухал ач холбогдолтой мэдээлэл болох юм.



барууны үзэл суртлууд нь эдийн засагт төрийн оролцоо бага байх ёстой гэж үздэг бол зүүний үзэл суртлууд нь эдийн засагт төрийн оролцоо их байх ёстой гэсэн хоёр туйлаар хуваагддаг. Орчин үеийн үзэл суртлууд баруунаас төв рүү, зүүнээс төв рүү шилжих хандлага ажиглагдаж байгаа. Мөн эдийн засаг дахь төрийн оролцооноос үүдэн хүний эрх, эрх чөлөөнд хандах хандлага өөрчлөгддөг. Баруун тийш шилжих тусам хүнийг эрх, эрх чөлөөг зөвшөөрдөг бол, зүүн тийш шилжих тусам хүний эрх хязгаарлагддаг. Энэхүү шугаман спектрм нь онолын загварчлал бөгөөд заавал ийм байна гэсэн үг бас биш. Жишээ нь АНУ-ын ардчилсан нам либерал үзэл суртлыг чиг баримжаагаа болгодог бөгөөд шугаман спектрм дээр зүүн төвд байршуулдаг. Мөн БНХАУ коммунист улс төрийн тогтолцоотой ч зах зээлийн эдийн засгийг чухалчилдаг.

### **Монголын улс төрийн намуудын үзэл баримтлал**

Монгол Улс хүний эрх, олон ургалч үзлийг дэмждэг, олон намын тогтолцоотой ардчилсан улс бөгөөд 1992 оны Үндсэн хуулиар *иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ* (Монгол Улсын Үндсэн Хууль, 1992), мөн Улс төрийн намын тухай хуулиар *иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдлийг улс төрийн нам* (Улс төрийн намын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2023) гэж тодорхойлсон.

Өнөөдрийн байдлаар Улсын Дээд шүүхэд 37 улс төрийн нам бүртгэлтэй байгаа ч тэд ямар үзэл баримтлалтай, үзэл баримтлалаа бодлого, үйл ажиллагаандаа тусгадаг эсэх нь тодорхойгүй, намууд үнэт зүйл, үйл ажиллагаагаараа ялгагдахгүй байна (Ё.Довчин, 2009) гэж судлаачид дүгнэдэг.

Монгол Улс 1990 онд социалист тогтолцооноос ардчилсан тогтолцоонд шилжсэнээр төрөөс засаглагч намын үзэл суртлыг тулгахаа больж хүний эрх, эрх чөлөө, олон ургалч үзэл, олон намын тогтолцоог зөвшөөрснөөр намууд зэрэгцэн үйл ажиллагаа явуулж, хөгжлийн төлөө олон ургалч бодлогоор уралдуулах болсон. Гэвч улс төрийн намууд сонгосон үзэл баримтлалдаа үнэнч байгаа эсэх, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө үзэл баримтлалдаа тулгуурлан боловсруулсан эсэх нь тодорхойгүй байсаар байна.

1. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар УИХ-д суудалтай болсон МАН, АН, ҮЭ, ИЗНН, ХҮН намуудын албан ёсны баримт бичгүүдийг судлахад МАН, АН, ИЗНН намуудын улс төрийн чиг баримжаа нь тодорхой байна. Харин ҮЭ, ИЗНН, ХҮН намууд яг ямар үзэл суртлыг сонгосон нь дүрэм, мөрийн хөтөлбөрт тодорхойгүй байсан. Тиймээс намууд ямар чиг баримжаатай, ямар үзэл суртлыг чухалчилж байгаа, өөрсдийн улс төрийн зорилгоо илүү тодорхой зарлах хэрэгтэй байна.
2. Монголын улс төрийн намууд өөрсдийн үзэл баримтлал, үнэт зүйл, зарчим, эрхэм зорилгодоо нийцсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулсан эсэх нь эргэлзээтэй байна. Намуудын дүрэм, үзэл суртлаа тодорхой болгочихвол сонгуулийн мөрийн хөтөлбөр нь уялдаатай эсэхийг тодорхойлох боломж бүрдэнэ.
3. Намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн асуудалд онцын ялгаа ажиглагдахгүй, хийх ажлын бүлэглэсэн жагсаалт байна. Цаашид улс төрийн намууд бодлогын нам болохын тулд тухайн амлалтыг хэрхэн хэрэгжүүлэх арга замаараа ялгардаг улс төрийн соёлд суралцах хэрэгтэй байна.


Намуудын үзэл баримтлал тодорхойгүй байгаа нь намыг бодлогын институт болж төлөвшихөөс гадна сонгогчдын улс төрийн боловсрол, хандлага төлөвшиж саад болж байна.

Тиймээс цаашид намууд үзэл баримтлалаа зарлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө үзэл баримтлал дээрээ тулгуурлаж боловсруулах, хэрхэн хэрэгжүүлэх арга зам, тооцооллоор өрсөлддөг, мэтгэлцдэг болох, мөн үнэт зүйл, үзэл баримтлалдаа тууштай байх нь Монголд ардчилал бэхжих, олон намын тогтолцоо төлөвшихөд тустай.

### Иргэдийн улс төрийн үзэл баримтлал


Улс төрийн үзэл баримтлалыг дээрх үзүүлэлтүүдэд хариулсан байдлаар багцлан давамгайлсан байр суурийг тогтоож тухайн иргэний улс төрийн үзэл баримтлал хэмээн тодорхойлсон. Иймд дараах тодорхойлсон улс төрийн үзэл баримтлал нь туйлын, үнэмлэхүй итгэл үнэмшил биш бөгөөд давамгайлагч байр суурь болно.

График 1. Иргэдийн улс төрийн үзэл баримтлалын тойм



Судалгаанд хамрагдсан иргэдийн 34.2 хувь нь социал демократ, 31.2 хувь нь консерватив, 22.2 хувь нь либерал давамгайлсан улс төрийн үзэл баримтлалтай хэмээн энэхүү судалгааны үр дүнд гарлаа. Харин тус гурван үзэл баримтлалын хувьд адил тэгш шинж чанарыг агуулсан буюу холимог улс төрийн үзэл баримтлалтай иргэд 3.9 хувийг бүрдүүлж байна. Социал демократ болон консерватив 3.8 хувь, социал демократ болон либерал 1.9 хувь, либерал болон консерватив үзэл баримтлалын холимог шинж чанарыг агуулсан иргэд 2.9 хувийг тус тус бүрдүүлж байна.

График 2. Улс төрийн үзэл баримтлал, насны бүлгээр



Судалгаанд оролцогчдын нас нэмэгдэх тусам консерватив үзэл баримтлалтай байх нь нэмэгдэж байна. Фокус бүлгийн ярилцлагын явцад иргэд социалист нийгмийн үеийг илүү үйлдвэртэй, хүн бүр ажилтай байсан гэх үндэслэлээр дэмжих нь түгээмэл байсан. Энэ нь уламжлалт, консерватив үзлийг өндөр байхад нөлөөлж байх магадлалтай. Нас залуужих тусам либерал




Улс төрийн үзэл баримтлалыг хөдөлмөр эрхлэлтийн салбараар нь харьцуулан дээрх графикт дүрсэллээ. Тус үзүүлэлтээс харахад төрийн байгууллагууд болон малчид, оюутан сурагчдын дунд социал демократ үзэл баримтлал хүчтэй илэрч байлаа. Харин либерал үзэл баримтлал нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон хувийн секторт ажиллаж буй иргэдийн дунд илүүтэй өндөр байна. Консерватив үзэл баримтлал нь тэтгэврийн болон группийн орлоготой хэсэг, зарим төрийн байгууллагууд, болон хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэгчдийн дунд өндөр байна.

### Улс төрийн үзэл баримтлалын талаарх иргэдийн өөрсдийн байр суурь


Нийт судалгаанд хамрагдсан иргэдээс өөрийн улс төрийн үзэл баримтлалыг хэрхэн тодорхойлж байгааг нэг асуулгаар тодруулахад дараах үр дүн гарлаа.

График 6. Иргэд өөрийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлсон байдал (хувиар)



Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн талаас илүү хувь нь 52.5 хувь өөрийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлон хэлж мэдэхгүй байна. Өөрийгөө улс төрийн аль нэг үзэлд хамааруулж үзсэн иргэдээс хамгийн өндөр буюу 18.2 хувь нь либерал үзэл баримтлалтай, 7.8 хувь нь социал демократ үзэл баримтлалтай гэж хариулсан. Өөрийн үзэл баримтлалыг хэрхэн тодорхойлсон байдлыг дээрх графикт илэрхийлсэн бол шалгуур асуулгаар улс төрийн үзэл баримтлалд хэрхэн ангилагдсан байдлыг дараах графикт харууллаа.

График 7. Иргэдийн өөрийгөө тодорхойлсон улс төрийн үзэл баримтлалыг бодит байдалтай харьцуулсан нь



Дээрх графикт босоо баганад өөрийгөө хэрхэн тодорхойлсон байдлыг, хэвтээ график дагуу шалгуур асуулгаар хэрхэн тодорхойлогдсон байдлыг дүрслэн харууллаа. Нэгж судалгаанд оролцогч иргэн бүр аль нэг улс төрийн үзэл баримтлалд шууд, бүрэн хамаарах нь цөөн байлаа. Тухайлбал нийгмийн тодорхой асуудлуудад өөр өөр байр суурийг илэрхийлж байсан нь манай орны иргэдэд улс төрийн туйлын итгэл үнэмшилтэй байдал сул байгааг илэрхийлж байна. Түүнчлэн өөрийгөө аль нэг улс төрийн үзэл баримтлалд хамааруулж үзэж байгаа нь бодит байдалтай тэр бүр нийцэхгүй байгаа нь судалгаагаар тогтоогдсон.

Өөрийгөө либерал улс төрийн үзэл баримтлалд хамаатуулан үзэж байсан иргэд судалгааны хамгийн өндөр хувийг буюу 18.2 хувийг бүрдүүлж байсан. Гэсэн хэдий ч судалгааны шалгуур асуултаар либерал үзэл баримтлалд хамаарах иргэд хамгийн бага хувийг бүрдүүлж байсан. Тиймээс тус хариултыг сонгосон иргэдийн шалгуур асуултаар хэрхэн тодорхойлогдож буй байдлыг дээрх графикт харууллаа.

### Нийгмийн институтийн үйл ажиллагааны талаарх иргэдийн байр суурь ба улс төрийн үзэл баримтлал

Судалгаанд оролцсон иргэд улс төрийн үзэл баримтлалыг иж бүрэн цогцоор нь баримталдаг бус асуудал тус бүрээс шалтгаалж ялгаатай байр суурь баримталж байна. Үүнийг дараах үзүүлэлтээс харж болно. Тухайлбал судалгаанд оролцогчид хувь хүний эрх, гэр бүлийн харилцаанд либерал давамгайл; баялгийн хуваарилалт, нийгмийн үйлчилгээнийх үрээнд социал демократ давамгайл; байгаль орчин, эдийн засаг дахь төрийн оролцоо болон цагаачлал, буу зэвсэг эзэмших зэрэг асуудалд консерватив үзэл баримтлалыг давамгайл дэмжиж байна.

Хүснэгт 1. Бүлэг асуудал тус бүрд давамгайлсан үзэл баримтлал

Либерал	Социал демократ	Консерватив
Хүний эрх Гэр бүлийн харилцаа	Баялгийн хуваарилалт Эрүүл мэндийн үйлчилгээ Боловсролын үйлчилгээ	Төрийн өмч Эдийн засаг дахь төрийн оролцоо Нийгмийн баялаг Байгаль орчин Цагаачлал Зэвсэг эзэмших

Хүснэгт 2. Нийгмийн голлох салбарын асуудал тус бүрд хандах ялгаатай, давамгайлах байр суурь

Үндсэн үзүүлэлт	Дэд үзүүлэлт	Консерватив	Либерал	Социал демократ
Төрийн зохион байгуулалт	Төр засаг өмчтэй, үйлдвэртэй байх ёстой эсэх	36.5%	34.6%	28.9%
Эдийн засаг	Эдийн засаг дахь төрийн оролцоо	45.4%	18.6%	36.0%
	Нийгмийн баялгийн талаар төрийн баримтлах бодлого	54.1%	39.4%	6.5%
	Төр баялгийг тэгш хуваарилах үүрэгтэй эсэх	24.0%	9.2%	66.8%
Нийгмийн бодлого	Эрүүл мэндийн үйлчилгээ	33.0%	16.9%	50.1%
	Боловсролын үйлчилгээ	8.3%	36.7%	55.0%
Хүний эрх	Хувь хүний эрх нийгмийн аюулгүй байдлаас илүү чухал	21.1%	41.1%	37.8%
	Төр хэвлэл мэдээлэл болон нийгмийн сүлжээнд хяналт тавих эсэх	32.5%	39.5%	28.0%
Гэр бүл	Гэр бүлийн амьдралын талаарх байр суурь	11.7%	55.5%	32.8%
Байгаль орчин	Байгаль орчныг хамгаалах бодлого	49.5%	14.1%	36.4%
Цагаачлал	Гадаадын иргэдийн Монгол улсад цагаачлуулах талаарх байр суурь	45.7%	36.1%	18.3%
	Буу галт зэвсэг эзэмших асуудал	51.4%	17.6%	31.0%

Дээрх хүснэгтэд үндсэн долоон шалгуур үзүүлэлт, 12 дэд үзүүлэлтэд эзлэх улс төрийн үзэл баримтлал тус бүрийн эзлэх хувийг харуулав. Судалгаанд хамрагдсан иргэд *төрийн зохион байгуулалт, эдийн засгийн хүчин зүйл, байгаль орчин, цагаачлалын бодлогын хувьд консерватив* үзэл баримтлал давамгайлж байлаа.

Харин нийгмийн бодлого буюу нийгмийн үндсэн үйлчилгээ болох *боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний* хувьд **социал демократ** үзэл баримтлалтай байна.

Хүний эрхийн асуудал болон гэр бүлийн харилцааны хувьд **либерал** үзэл баримтлалд түлхүү хамаарч байна.

## Дүгнэлт

Иргэд бүхий л асуудлыг аль нэг улс төрийн үзэл баримтлалын хүрээнд дүгнэх нь ховор бөгөөд нийгмийн салбар, асуудал тус бүрд ялгаатай үзэл баримтлалтай буюу ялгаатай байр суурьтай байна. Тиймээс бүхэллэг байдлаараа аль нэг үзэл баримтлалыг тууштай баримтлах байдал монголын нийгэмд сул. Нийгмийн онцлог, түүхэн цаг хугацаанд бүрэлдсэн олон нийтийн сэтгэлгээний хэв шинж, иргэдийн туршлагаас хамаарч сонгодог утгаараа улс төрийн үзэл баримтлал тогтоогүй байна.

Улс төрийн үзэл баримтлал нь улс төрийн үйл ажиллагаа, бодлого боловсруулахад суурь үндэс болдог чухал ач холбогдолтой ч иргэдийн хувьд улс төрийн үзэл баримтлалын талаар тогтсон ойлголт бүрдээгүй байна.

Монголчууд төрийн зохион байгуулалт, эдийн засгийн асуудлаар консерватив үзэл баримтлал давамгайлдаг бол нийгмийн бодлого буюу боловсрол эрүүл мэндийн асуудлаар социал демократ чиг баримжаа баримтлах нь нийтлэг буюу тус салбар дахь төрийн оролцоо, зохион байгуулалт зайлшгүй шаардлагатай гэж үзэх нь түгээмэл байна. Харин хүний эрх болон гэр бүлийн асуудлаар либерал үзэл баримтлал бүхий чиг баримжаа давамгайлж байна. Байгаль орчны асуудлаарх иргэдийн хандлага болон цагаачлал галт зэвсэг эзэмших талаарх асуудлаар иргэдийн дунд консерватив үзэл баримтлал түлхүү давамгайлж байна.

Засаглалын хэлбэрийн талаарх иргэдийн байр суурь гол төлөв парламентын тогтолцоо, төлөөллийн ардчиллыг хамгийн зохист улс төрийн хэлбэр гэдэгтэй санал нийлж байна. Тухайлбал манай улсын хувьд тохиромжтой тогтолцоог судалгаанд оролцсон иргэдийн 53.3 хувь парламентын тогтолцоо, 30.6 хувь нь ерөнхийлөгчийн тогтолцоо гэжээ.

Улс төрийн намууд үзэл баримтлалаа олон нийтэд таниулах, сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгах, тууштай байх нь сонгогчдын саналыг татахаас гадна намын төлөвшил, сонгогчдын боловсрол, улс төрийн соёлд нэн чухал. Гэвч улс төрийн намууд төлөвшөөгүй, улс төрийн үзэл баримтлалдаа тууштай байж мөрддөггүй нь улс төрийн намууд чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгааг харуулж байна.

## Ашигласан материалын жагсаалт

- Britannica encyclopedia. <https://www.britannica.com/topic/political-party>
- Идеологи. <https://mn.wikipedia.org/wiki/%D0%98%D0%B4%D0%B5%D0%BE%D0%BB%D0%BE%D0%B3%D0%B8>
- Andrew Heywood. Introduction to Politics. 2005
- Political spectrum. <https://www.britannica.com/topic/political-spectrum>
- Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
- Улс төрийн намын тухай хууль (шинэчилсэн найруулга) 2023 он. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760239349461>
- Ё.Довчин, Г.Цэнд-Аюуш “Улс төрийн үзэл суртал ба намуудын үзэл баримтлал” ПОЛИТОЛОГИ V. Эрдэм шинжилгээний бичиг. № 325 (51)
- Я.Төгөлдөр нар “Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал” ШУТИС. ННФ. 2021 он.
- С.Мөнхбат, Б.Эрдэнэдалай “Монголын улс төрийн намын үзэл баримтлал, түүний хэрэгжилтийн зарим асуудал” ПОЛИТОЛОГИ XXII. Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 70-81 дэх тал.